



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

20220727 № 0579720  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Баасанжавын Орхонтуул, Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлтсийн Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төслийн зардал, ашгийн тооцоо, судалгаа хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Нямаагийн Мөнхбаяр, Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Батжаргалын Дөлгөөн нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,  
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Б.БАЯРСАЙХАН

1422003013923